


2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


“ИНВЕСКОР ББСБ” ХК
/НЭГТГЭСЭН/



ГОЛ АМЖИЛТУУД

- ✓ Чанарын удирдлагын ISO 9001 болон Мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001 стандартыг нэвтрүүлж байна.
- ✓ 2020 оны жилийн эцсийн тайланд дэлхийн Топ-5 аудитын фирмийн нэг болох “БДО Аудит”-р аудит хийлгэж баталгаажуулсан.
- ✓ Бүрэн автоматжсан “Дижитал” салбарыг үйл ажиллагаандаа шинээр нэвтрүүлсэн.
- ✓ Улаанбаатар хотод “Авто Экспо” салбар, Киргиз улсын Бишкек хотод “Ош” дэд салбарыг шинээр байгуулсан.
- ✓ Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны “хамтрагч гишүүн” болсон.
- ✓ Монголын Банкны Холбооны гишүүнээр элссэн.
- ✓ “Тогтвортой Санхүүгийн Холбоо (ТоС Холбоо)”-ны үндсэн гишүүнээр элссэн.

КОМПАНИЙН НЭГДЛИЙН БҮТЭЦ



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

- ✓ "Инвескор ББСБ" ХК нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2021 оны 4 сарын 23-ны өдөр компанийн веб сайтаар дамжуулан цахим хэлбэрээр зохион байгуулна.
- ✓ Хурлын хэлэлцэх асуудлууд нь:
 1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайланг танилцуулах
 2. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны төсөв батлах
 4. Зарим зээлийн эх үүсвэрийг хоёрдогч өглөгрүү хөрвүүлэхийг хэлэлцэн батлах
 5. Бусад
- ✓ Хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 3-р сарын 23-ны өдрөөр тогтоосон болно.

НОГДОЛ АШИГ


- ✓ "Инвескор ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 2-р сарын 19-ны өдрийн № А/04-Т тоот тогтоолоор 2020 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 17.00 төгрөг буюу нийт 1.22 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигч нартаа тараахаар шийдвэрлэсэн.
- ✓ Энэхүү ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 3-р сарын 23-наар тогтоосон бөгөөд ногдол ашгийг 2021 оны 4-р сарын 30-ны дотор хувьцаа эзэмшигчдийн "ҮЦТХТ" ТӨХХК дахь дансанд байршуулахаар шийдвэрлэсэн.



2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


ХУВЬЦААНЫ АРИЛЖАА

Хувьцааны ханш ба арилжааны дүн



- ✓ 2021 оны 1-р улирлын эцсийн байдлаар хувьцааны ханш оны эхнээс **8% хувиар** өсч **3185 төгрөгт** хүрсэн байна.
- ✓ IPO хийсэн цагаас хойш хувьцааны ханш нийт **89% хувиар** өссөн амжилттай байна.
- ✓ Зах зээлийн үнэлгээ нь **228.5 тэрбум** төгрөгт хүрч өссөн бөгөөд
- ✓ 2020 онд **6.01 тэрбум** төгрөгийн арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны арилжааны **10 хувийг** эзэлсэн байна.
- ✓ Нийт арилжааны дүнгээр 2020 оны **хамгийн идэвхтэй** арилжаалагдсан хувьцаа болсон.

БОРЛУУЛАЛТЫН СУВАГ




- ✓ 2021 оны 1-р улиралд “Уран Ган” авто худалдааны төвийн дэргэд “Авто Экспо” салбар нээгдсэнээр нийт 14 салбартай боллоо.
- ✓ Манай 12 салбар Улаанбаатар хотод, 1 салбар Эрдэнэт хотод үйл ажиллагаа явуулж байна.
- ✓ Төлөвлөгөөний дагуу бид 2021 онд дахин 7 шинэ салбар нээх бөгөөд үүнийг нэг нь орон нутагт байхаар төлөвлөж байна.



- ✓ 2021 оны 1-р улиралд биет салбарыг 100% орлох, үйл ажиллагаа нь бүрэн автоматжсан Дижитал салбарыг амжилттай нэвтрүүлээ.
- ✓ Одоогийн байдлаар уг салбар нь лизингийн зээл болон смарт киоскуудын үйл ажиллагааг хариуцан удирдаж байна.
- ✓ Дижитал салбар нь харилцагч нарын зээлийн хүсэлтийг цахимаар авч, зайнаас судлах ба онлайнаар ярилцлага хийж холбогдох шийдвэрийг гаргах юм.

ИНВЕСКОР АЛЛИАНС

- ✓ 2021 оны 1-р улирлын байдлаар “Инвескор Аллианс” хөтөлбөрийн гишүүнээр Өмнөговь болон Дорнод аймгийн ББСБ нар ажиллаж байна.
- ✓ 2021 оны 2-р улиралд Өвөрхангай, Сэлэнгэ, Увс аймгийн ББСБ-уудыг хөтөлбөрийн гишүүнээр элсүүлэхээр төлөвлөж байна.
- ✓ Инвескор ББСБ ХК нь орон нутгийн ББСБ-уудыг чадавхижуулж, шаардлагатай эх үүсвэрийг хангаж ажилласнаар орон нутгийн жижиг дунд бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжиж, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.



КИРГИЗ УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ


- ✓ “Инвескор ББСБ” ХК нь Монголтой соёл болон бусад зүйлээрээ адил төстэй хөгжиж буй орнуудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ экспортлох бодлого баримталдаг.
- ✓ Киргиз дахь охин компани болох “Золотой Стандарт” бичил санхүүгийн байгууллага нь 2021 оны 1-р улирлын байдлаар нийт 1.3 тэрбум төгрөгийн зээл олгосон бол 484 сая төгрөгийн зээл эргэн төлөгджээ.
- ✓ Нийт зээлдэгчдийн тоо 341-т хүрч 2020 оны эцсээс 34 хувиар өссөн, зээлийн багц 3.3 тэрбум төгрөгт хүрч 2020 оны сүүлээс 31 хувиар өссөн амжилттай байна.
- ✓ 2021 оны 1-р улиралд Бишкек хотын хамгийн хөл хөдөлгөөнтэй Ош захын хажууд дэд оффисоо нээсэн бөгөөд энэ ондоо багтаан Ош хотод нэг салбар, Бишкек хотод 2 дэд оффис нээхээр төлөвлөж байна.
- ✓ “Покет Киргиз” охин компанийн хувьд Киргиз улсын зах зээлд зориулсан цахим зээл, дижитал хэтэвчийн туршилтын хувилбарыг амжилттай нэвтрүүлсэн бөгөөд оны эхний хагаст багтаан зах зээлд танилцуулахаар төлөвлөж байна.




2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЗЭЭЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮН

Зээлийн багц




Зээл олголт, эргэн төлөлт (сая төгрөг)




- ✓ Нийт зээлийн багц өмнөх оны мөн үеэс 63 хувиар, өсч 108.5 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- ✓ Нийт зээлдэгчийн тоо 2020 оны сүүлээс 10 хувиар өсч 61,798 болсон байна.
- ✓ Зээлийн багцад эзлэх хугацаа хэтэрсэн зээлийн хувь 2.7%, чанаргүй зээлийн хувь 2.8% байна.
- ✓ 2021 оны 1-р улиралд зээл олголт өмнөх оны мөн үеэс 150 хувиар өссөн бол эргэн төлөлт 117 хувиар өсчээ.
- ✓ Цар тахлын хүнд цаг үед бид сегментэд суурилсан нээлттэй борлуулалтын тактикийг баримталж ажилласан.
- ✓ Үүний үр дүнд зээлийн эрсдлийг зохистой түвшинд хадгалахын хажуугаар багцаа өсгөж байна.

САНХҮҮГИЙН ГОЛУР ДҮНГҮҮД


Нийт хөрөнгө (сая төгрөг)




Өөрийн хөрөнгө (сая төгрөг)



Зээлийн багц (сая төгрөг)



Хүүгийн орлого (сая төгрөг)



2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

сая төгрөг	2019	2020	2021.I
ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5,146	26,589	14,857
Хөрөнгө оруулалт	3,600	591	1,855
Харилцагчдад олгосон зээл-цэвэр	60,645	92,548	105,838
<i>Нийт зээл</i>	<i>61,950</i>	<i>95,291</i>	108,500
<i>Эрсдэлийн сан</i>	<i>(1,305)</i>	<i>(2,742)</i>	(2,661)
Хүүний авлага	1,663	3,861	7,375
Авлага	-	1,534	4,630
Өмчлөх бусад үл хөдлөх хөрөнгө	1,056	822	375
Бусад актив	2,310	492	1,089
Үндсэн ба биет бус хөрөнгө	7,483	9,503	9,013
Нийт хөрөнгийн дүн	81,902	135,941	145,032
ӨР ТӨЛБӨР			
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	19,934	42,210	38,241
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	14,516	14,100	18,745
Бонд	-	7,879	7,760
Бусад өглөг	7,064	19,055	25,625
Нийт өр төлбөрийн дүн	41,513	83,244	90,370
ӨӨРИЙН ХӨРӨНГӨ			
Хувьцаат капитал	16,282	16,282	16,282
Нэмж төлөгдсөн капитал	15,378	15,378	15,378
Хуримтлагдсан ашиг / (алдагдал)	8,729	21,037	23,001
Нийт өөрийн хөрөнгө	40,389	52,697	54,661
Нийт пассив ба өөрийн хөрөнгө	81,902	135,941	145,032

2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ОРЛОГО ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

сая төгрөг	2019	2020	2021.I
Хүү болон түүнтэй адилтгах орлого	19,363	29,148	8,436
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4,072	6,755	2,551
Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал	57	1,298	1,162
Хүүгийн цэвэр орлого	15,234	21,094	4,723
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	2,600	450	151
Ажиллагсадтай холбогдолтой зардал	3,001	3,170	1,326
Үйл ажиллагааны бусад зардал	3,395	4,116	1,948
Ханш, үнэлгээний тэгшитгэлийн орлого (зардал)	159	87	564
Бусад олз (гарз)	(280)	(634)	
Үйл ажиллагааны ашиг	11,317	13,711	2,164
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(110)	7	818
Татварын өмнөх ашиг (алдагдал)	11,208	13,718	2,982
Орлогын албан татвар	2,549	2,286	301
Зогсоосон үйл ажиллагааны алдагдал		28	
Тайлант жилийн ашиг (алдагдал)	8,659	11,460	2,681
Эрсдлийн сангийн нөөц, гадаад валют хөрвүүлэлтийн олз (гарз)	16	(56)	
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг (алдагдал)	8,675	11,404*	2,681

* НББОУС-н дагуу өмчийн өөрчлөлтийн тайланд тусгагдсан тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг нь 12.3 тэрбум төгрөг болно.

2021 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД (тусдаа)

Шалгуур үзүүлэлт	Байх ёстой	2019	2020	2021.I
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	10%-с доошгүй	47.6%	39.1%	34.8%
Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн нийт активын харьцаа	20%-с доошгүй	47.6%	39.1%	34.8%
1-р зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын харьцаа	10%-с доошгүй	50.1%	37.3%	36.7%
Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	8%-с дээш	10.9%	34.5%	18.4%
Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	30%-с хэтрэхгүй	9.4%	7.7%	8.2%
ББСБ-с гаргасан төлбөрийн баталгааны зохистой харьцаа	70%-с хэтрэхгүй	0.0%	0.0%	0.0%
Нийт холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	25%-с хэтрэхгүй	0.6%	0.6%	0.6%
Нэг холбогдох этгээдэд олгосон зээл / Өөрийн хөрөнгө	10%-с хэтрэхгүй	0.1%	0.1%	0.1%
Үнэт цаасны эзэмшил / өөрийн хөрөнгө	50%-с хэтрэхгүй	9.7%	12.4%	12.9%
Гадаад актив, пассивын зөрүү өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	+/-40%-с хэтрэхгүй	13.9%	18.4%	22.2%
Итгэлцлийн өглөг өөрийн хөрөнгийн зохистой харьцаа	80%-с хэтрэхгүй	46.0%	78.1%	73.8%
Өрийн бичгийн зохистой харьцаа	50%-с хэтрэхгүй	0.0%	15.3%	15.0%
Үндсэн хөрөнгийн зохистой харьцаа	15%-с хэтрэхгүй	7.8%	3.5%	4.2%


ПОКЕТ ПЛАТФОРМ – ГОЛ БҮТЭЭГ ДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ



2020 оны онцлох бүтээгдэхүүн: Покет зеро 100+ брэнд, 100+ салбар



Түүнчлэн харилцагч нартаа зориулж төлбөрөө хуваалцах, чат, мөнгөтэй дугтуй илгээх, банкны карт холбох үйлчилгээг нэвтрүүлсэн.



InvesCore
САНХҮҮГИЙН ГРУПП

www.invescore.mn

info@invescore.mn

+976-7709-0077